



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

16 /230/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.20

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр 1933 он.

ЦЭРГИЙН ҮҮРЭГТНИЙ ҮНЭМЛЭХ, ТАЛАРХАЛ ГАРДУУЛЛАА



Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Нийслэлийн хэмжээнд 2022 оны цэргийн бүртгэл 1 дүгээр сарын 5-21-

ний өдрүүдэд E-Mongolia цахим портал, мөн засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулагдан

явагдаж байна. Энэ хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб өчигдөр 10, 15 дугаар хороодын 18

нас хүрсэн иргэдэд цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулав.

Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн алба хаах төрлүүд, хугацаат цэргийн алба хаахын давуу талуудын талаар мэдээлэл хийж, эх орныхоо өмнө хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлэх боломж нээгдэж байгаад баяр хүргэн, цаашдын сурлага, хөдөлмөрт өндөр амжилт хүсэж, цэргийн үүрэгтний үнэмлэх, дүүргийн Засаг даргын "Талархал" гардуулсан юм.

Тус арга хэмжээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер, хурандаа М.Мөнгөнтулга, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа О.Мөнхжаргал, 10 дугаар хорооны Засаг дарга Ц.Амаржаргал, 15 дугаар хорооны Засаг дарга Ж.Булганцэцэг болон шинээр цэргийн бэлтгэл үүрэгтэн болсон иргэдийн эцэг эхийн төлөөлөл оролцлоо.

Монгол Улсын хил хязгаарын хамгаалалтын зарим хэсгийг Дотоодыг Хамгаалах газарт шилжүүлжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-27

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,853.0	2,855.0
EUR	3,257.0	3,264.0
CNY	449.00	450.00
RUB	38.00	38.70
JPY	24.90	25.00
KRW	2.39	2.40

ЗУРХАЙ

2022.01.20 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Эд малын гарлагатай

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.33-17.33

Барилдлага:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА: Төрөхүй

Суудал:

Шороо

Энэ өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

30 КМ ЯВГАН МАРШААР...



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Ангийн сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 30 км-ийн явган маршийг өчигдөр явууллаа. Маршийн явцад бие бүрэлдэхүүнтэй явуулах хичээлийг 3 цэгт /цөмийн дэлбэрэлтийн гялс хийлтээр ажиллах, тактикийн ажиллагааг гүйцэтгэх, газар оронд тактикийн болон байр зүйн баримжаалал хийх/ төлөвлөж зохион байгуулав. Түүнчлэн түр амралтын үед соёл хүмүүжлийн ажил зохиож бие

бүрэлдэхүүний дунд уулын оргил эзлэх тэмцээнийг явуулсан юм. Тус тэмцээний тэргүүн байрыг дэд ахлагч М.Намсрай, хоёрдугаар байрыг дэслэгч Т.Амаржаргал, гуравдугаар байрыг ахлах дэслэгч Ц.Лхагвасүрэн нар тус тус эзэлж хамт олноо манлайллаа.

Мөн маршийг 4 бүлгээр зохион байгуулж, урьдчилан бэлтгэсэн солбилцлыг бүлгийн дарга нар, цэргийн байр зүйн зурагт оруулан бие дааж тус тусын маршрутаар хөдөлгөөн үйлдсэнээрээ онцлог байлаа.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

I ТУН 2,268,377 +169,7%/	II ТУН 2,168,827 +166,7%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ I ТУН 979,390 +130,0%/
-----------------------------	------------------------------	---

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7649 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 196	ЭДГЭРСЭН 7337
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 339,146,038
Эдгэрсэн Нийт: 272,803,813
Нас барсан Нийт: 5,583,023

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Их хүйтэн болох улирал (10 цаг 52 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Цахим шууданд

РАДИОТЕЛЕГРАФЧИН БЭЛТГЭХ ДАМЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



шалгаруулан авч 45 хоногийн сургалтыг зохион байгуулсан юм.

Сургалтын төгсгөлд Агаарын цэргийн командлалаас томилогдсон дэд хурандаа О.Сайнжаргалаар ахлуулсан комиссуралцагчдаас шалгалт авч тэнцсэн бүрэлдэхүүнд гэрчилгээ гардууллаа. Мөн дөрвөн суралцагч радиотелеграфчины хоёрдугаар зэрэг, найман суралцагч гуравдугаар зэргийн болзлыг хангаж зэргийн үнэмлэхээ гардан авла

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Тус анги Агаарын командлагчийн тушаалаар Завхан аймгийн ЗДТГ-ын цэргийн штабтай хамтран радиотелеграфчин бэлтгэх дамжааг ангийн байрлалд, сургалтын материаллаг баазыг түшиглэн амжилттай явууллаа.

Бие бүрэлдэхүүний нөхөн хангалтыг бүрдүүлэх, мэргэжлийн зэрэгтний тоог нэмэгдүүлэх зорилготойгоор нийт 16 суралцагчийг Завхан аймгийн сум, орон нутгаас цэргийн алба хаасан 19-22 насны залуучуудаас сонгон



Г.К.ЖУКОВЫН ДУРСГАЛЫН МУЗЕЙ



ЗХУ-ын цэрэг улс төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар, Маршал Георгий Константинович Жуковын байгуулсан алдар гавьяаг дэлхийн улс түмэн өнө мөнхөд дурсан санаж бахархдаг.

Халхын голын байлдааны ялалтын 40 жилийн ойг тохиолдуулан 1979 онд Георгий Константинович Жуковын дурсгалд зориулан энэ музейг нээжээ

Г.К.Жуков гэр бүлийн хамтаар 1939 оны 9 дүгээр сараас 1940 оны 5 дугаар сар хүртэл энэхүү музейн байшинд ажиллаж амьдарч байсан түүхтэй.

Тус музей нь үзүүлэнгийн гурван танхимтай. Г.К.Жуковын амьдрал үйл ажиллагаатай холбоотой түүхэн үнэнийг өгүүлэх гэрэл зураг, баримт бичгүүд, түүний

эдэлж хэрэглэж явсан эд зүйлс, Монгол, ЗХУ, Япон улсын цэргийн түүхийн архиваас сонгож авсан урьд хэвлэгдээгүй материалууд, Г. К. Жуковын гэрийнхэндээ бичсэн захидал, түүний гэр бүлийнхний дурсамж, ховор нандин түүхэн гэрэл зургийг эндээс үзэх боломжтой.



Дэлхийн II дайнд нэр нь дуурсан цэргийн гарамгай зүтгэлтэн тэрээр Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө тэмцэлд үнэлж баршгүй гавьяа байгуулсны учир 1981 онд Г.К.Жуковын хөшөөг тус музейн дэргэд байгуулж, хүндэтгэл үзүүлж байдаг юм.

Эрүүл мэнд

КОРОНАВИРУСЫН ЭРГЭН ТОЙРОНД



Сүүлийн хоёр жил дэлхий нийтээрээ "Коронавирус" хэмээх халдварт өвчинд дарлуулж байгаа ч, өөрийгөө болон гэр бүлээ, бас найз нөхдөө хамгаалах бүрэн боломж байна. Үүнийг товчлон хүргэхийг бид зорилгоо.

Нэг: ГЭРЭЭСЭЭ ГАРЧ БОЛОХГҮЙ

Коронавирус (Ковид-19)-аар

амин дэмийг мөн 1000 мг-аар өдөрт нэг удаа 14 хоног ууна. 38 градусаас өндөр хэмээр халуурвал эмчид хандах нь зүйтэй.

Хоёр: ӨӨРТӨӨ АНХААРАЛ ТАВЬЖ, ЭМЧТЭЙГЭЭ ХОЛБООТОЙ БАЙГААРАЙ

Сайн амарч, эмчийн өгсөн зааврын дагуу эмээ цагт нь тогтмол уувал бүрэн эдгэрнэ. Өдөрт хоёр удаа биеийн халуунаа

багадаа 3 хоногийн дотор халуураагүй, амьсгалын замын эмгэг зовуурь илрээгүй бол ажиглалт, тусгаарлалт дуусна. Өвчин эхэлснээс өмнөх 14 хоногийн хугацаанд гэр бүлийн гишүүдээс гадна уулзсан хүний утас, нэр, гэрийн хаягийг өрхийн эмнэлэгт мэдэгдэх ёстой. Хэрэв та чихрийн шижин, жирэмсэн, бөөрний архаг



LIVE

КОРОНАВИРУСЫН ЭРГЭН ТОЙРОНД

өвчилсөн хүмүүсийн ихэнх нь хөнгөнөөр өвчилж байгаа тул гэртээ эдгэрэх боломжтой. Ийм үед эмнэлгийн тусламж авахаас бусад тохиолдолд аль болох гэрээсээ гарахгүй байхыг хичээгээрэй. Ялангуяа, олон нийтийн газраар явж болохгүйн зэрэгцээ өвөрмөц эмчилгээ хийх шаардлагагүй. Харин шингэн зүйл сайнууж, илчлэг сайтай хоол хүнс хэрэглэнэ. Шаардлагатай тохиолдолд халуун бууруулах, зовуурь багасгах, өвдөлт намдаах зэрэг эмчилгээг хийнэ. Д амин дэмийг 4000-5000 мг-аар өдөрт нэг удаа 14 хоног ууж хэрэглэнэ. С

хэмжинэ. Хэрэв танд, амьсгаадах, амьсгал давчдах, ханиалгалт эрс нэмэгдэх, амны салст, хэл, уруул хөхрөх зэрэг шинж тэмдэг илэрвэл өрхийн эмчдээ яаралтай хандах ёстой. Энэ үедээ нийтийн тээвэр, хувийн унаа зэргээр зорчиж эмнэлэгт очихоос зайлсхийгээрэй.

Гурав: ГЭРТЭЭ ТУСГААРЛАГДСАН БОЛ...

Коронавирус т халдварын хөнгөн тохиолдолд бусдад халдвар тараахгүй байж, халдвар хамгааллын дэглэмийг ягштал мөрдөнө. Гэрийн ажиглалтад 10 хоног байх ба хамгийн

дутагдал, хорт хавдар, цус харвалтын үлдэцтэй, гуурсан хоолойн бөглөрөлт эмгэг, астма зэрэг архаг хууч өвчинтэй бол хүндрэх эрсэлтэйг анхаараарай.

Энэ бүхэн нь хэнд ч мэдэх юм шиг санагдаж болох авч, "Хүн хэдий сайн ч хэлэхээс... цаас хэдий нимгэн ч чичихээс..." гэдэгтэй агаар нэгэн буй за!

АШУУИС-ийн Монгол Уламжлалт Анагаахын Төв Эмнэлгийн сувилагч Д.ЭНХЧИМЭГ, Ц.ЦЭВЭЛМАА, П.ДҮҮРЭНБАЯР СЭМҮТ-ийн сувилагч И.УЛАМБАЯР

